



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/45.

Мандалговь

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Мотоциклын хөдөлгөөнийг түр хориглох тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/23 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

Хоёр. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар(Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохдоо өөрийн болон бусдын биед гэмтэл учруулах, амь насыг хохироох зэргээс урьдчилан сэргийлэн хурдаа тохируулах, хамгаалалтын малгай хэрэглэх, замын бартаа сааданд болгоомжтой явахыг нийт иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210009